

СЭТГҮҮЛЧ Ц.ДАШДОНДОВЫН НИЙТЛЭЛИЙН ХЭЛ НАЙРУУЛГЫН ЗАРИМ ОНЦЛОГ

Л.Норовсүрэн*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхимийн багш, Шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор

Түлхүүр үг: ардчилал, хүний эрх, толь, даяг, хүндэт доктор, нийтлэл, урлан, оюуны орд, сөрж давах

Өнгөрсөн зууны наяд онд нийгмийн эмзэг газрыг гярхай олж харж, гал дөлтэй нийтлэлээрээ тодорч гарсан авьяаслаг сэтгүүлчийн нэг бол Ц.Дашдондов билээ. Түүнийг Монгол оронд өрнөсөн нийгмийн өөрчлөн байгуулалтын дууч, чөлөөт ардчилсан сэтгүүл зүйн "загалмайлсан эцэг" гэдгийг мэргэжлийн хүрээнийхэн сайн мэднэ. Тэрбээр наяд онд хурц асуудал хөндсөн ухаалаг хэрсүү санаатай нийтлэлээрээ өөрчлөн байгуулалтын үйл хэрэгт оюуныхаа хүчийг өргөж байсан бол, ерээд он гармагц Монголын сэтгүүлчдийн байгууллагыг шинэчлэх үйлсийг манлайлж явсан билээ. Түүний үүсгэн байгуулж, үйл ажиллагааг нь удирдан чиглүүлж байсан Монголын Чөлөөт Ардчилсан Сэтгүүлчдийн Эвлэл «ардчилал, хүний эрхийн тулгуур зарчим болсон хэвлэлийн эрх чөлөөг хөгжүүлэх, баталгаажуулах, үүслийн төдий байсан чөлөөт хэвлэлийг дэмжин зүгшрүүлэх, эрх зүйн орчин бүрдүүлэх, сэтгүүлчдийн эрхийг хамгаалах үйлсэд үнэтэй хувь нэмэр

оруулсан» тухай, Ц.Дашдондов өөрөө «нэрт сэтгүүлч төдийгүй, ардчилал, нийгмийн шударга ёсны төлөө тууштай тэмцэгч томоохон зүтгэлтэн»¹ болох тухай урьд өмнө өөр бүтээлд дэлгэрэнгүй өгүүлсэн билээ. Энэ удаад түүний туурвилын олон талт өвөрмөц онцлогийг эс өгүүлэн, зөвхөн уран бүтээлийн урлан руу нь цухас өнгийж, тэр дундаас нийтлэл, бүтээлийнх нь амин сүнс болсон хэл найруулгад өнгөцхөн боловч ажиглалт хийхийг зорилоо.

Юуны өмнө тэрбээр бичих сэдвээ оновчтой сонгон, ул суурьтай судалж, юмыг олон талаар эргэцүүлэн бодож, хүнд хэрэгтэй санаа хэлэхийг гол зарчмаа болгодог бөгөөд нэгэнт олсон санаа бодлоо бүрэн дүүрэн, товч тодорхой илэрхийлэх эрдэмд цагааширсан уран бүтээлч болохыг онцлон тэмдэглэвэл зохино. Энэ тухай өөр хүмүүсийн үнэлэлт, дүгнэлтүүд ч байна. Тухайлбал «Дашдондов гуай бичих гэж байгаа зүйлийнхээ зах зухаас нь ярих хүндээ ярина. Яах нь вэ гэсэн шиг сонжино. Тэгэхдээ санаа оноог нь заавал сонсох гэж шахахгүй. Тэгж байгаад нэг л мэдэхэд гаргаад ирнэ. Гэхдээ Дашдондовын гэсэн арилж баларшгүй онцлог, таньж

ядахгүй ялгамж байдаг. Хамгийн эхлээд сэдэв. Тэр ердийн юмны талаар огтхон ч бичихгүй. Мэдээллийг санасан газраасаа шүүрч аван, нэн өргөн, хэмжүүр сайтай тунгаан бодох үйл ажиллагаанд оруулж, тэрхүү санаагаа боловсруулж элдэнэ»² гэж сэтгүүлч До.Чулуунбаатарын бичсэнийг үзээд Ц.Дашдондовын хэлж байсан нэг үг санаанд буув. «Хүн ер нь аль болохоор дээшээ мацаж ухаантай, эрдэмтэй хүмүүсийн амжилт олсон нууцыг уудалж гаргахыг хичээх хэрэгтэй юм шиг байгаа юм. Учир нь тэгэх явцдаа хүн өөрөө өсдөг. Жишээ нь би гэхэд л их эрдэмтэн Чой. Лувсанжавтай танилцаж ойр дотно нөхөрлөөгүй бол өдийд арав гаруй толь бичгийн зохиогч болох байсан уу, үгүй юу. Тийм хүмүүс ойр орчноо нарны туяа, сарны гэрэл мэт гийгүүлж байдаг» гэсэн утгатай үг хэлсэн.

Ц.Дашдондовын бичсэн нийтлэл бүхэн олон нийтийн анхааралд өртөж, нөлөөлөх чадвар сайтай байдгийн нууцыг үг хэлний өвөрмөц онцлогтой нь холбон үзэж болно. Түүний найруулгын ур маяг, өөрийн гэсэн өнгө аяс хамгийн түрүүнд анхаарал татдаг. "Найруулга бол хүн өөрөө юм"³ гэсэн Бюффоны үгийг хэн нэг хүнд тааруулж болдог бол тийм хүн Ц.Дашдондов мөн. Өөрөөр хэлбэл Дашдондовын найруулга бол Дашдондов өөрөө юм гэж хэлж болно. Уран бүтээлчийн найруулгын өнгө аяс гэдэг бол тухайн уран бүтээлчийн өгүүлэх арга барилыг бусдынхаас ялгаруулж өгдөг өвөрмөц онцлог нь юм. Ийм онцлог юм бичдэг хүн бүрд заяагаад байдаггүй, гагцхүү асар их туршлага, авьяас билгийн үр дүн болж цогцолдог, нэг үгээр хэлбэл уран бүтээлчийн хөдөлмөрийг үнэлж тэнгэрээс хүртээсэн хишиг гэмээр ховор нандин зүйл юм. Ийм онцлог Ц.Дашдондовын

нийтлэлийн бүтээлд хэм хэмжээ болж тогтсон байна. Энэ нь сонин, сэтгүүлийн навтарсан хуудсанд зохиогчийн нэргүй, оноосон гарчиггүй "тэнэж" яваа бичвэрийн тасархайг үзээд энэ Ц.Дашдондовынх байна гэж танигдах давтагдашгүй өвөрмөц шинжээр илэрч байдаг.

Бүтээл туурвилын үг хэл тухайн зохиогчийн зан чанар, сэтгэхүйн хэв маягийг ямар нэг хэмжээгээр илэрхийлж байдаг гэдэгтэй олонх судлаач санал нийлдэг. Энэ нь мөнөөх "Найруулга бол хүн өөрөө юм" гэсэн алдарт үгтэй утга дүйж байгаа юм. Ц.Дашдондов бие хүнийхээ хувьд өөрийн гэсэн давтагдашгүй дүр төрхтэй, ижилсэшгүй хувь сэтгэлгээтэй, тэгэх тэгэхдээ бүр адайр, ааштай гэмээр зан төрхтэй хүн. Бас өөрийнхөө үнэ цэнг мэдэрдэг, тэр чанараараа бусдад ая тал засч, манж үг хэлж сураагүй, дургүй хүргэсэн хэнд ч хатуу ширүүн үгийг ил шууд хэлчихдэг зантай нэгэн. Тэр зан чанар нь бүтээл туурвилынх нь мөр бүхэнд илэрч байдаг онцлогтой. Тиймээс ч мэргэжил нэгт нөхөд нь түүнийг «Маш олон талтай, тэр бүхэн нь монгол дархны цоож мэт давхар давхар өргөстэй, өөр юутай ч зүйрлээд биччих аргагүй "цор ганц хувь хүн" бол энтэй сэтгүүлч, нэртэй тольч, нийгмийн томоохон зүтгэлтэн»⁴ гэж тодорхойлсон нь зүй ёсны юм.

Үг хэлийг сэтгэлгээний үргэлжлэл, бас түүний илрэн гарах хэлбэр гэдэг. Энэ үүднээс авч үзвэл цэгцтэй сэтгэдэг хүний үг цэгцтэй байх учиртай. Энэ зүй тогтлыг Ц.Дашдондовын нийтлэлийн логик дараалал, авцалдаа холбоо, өгүүлэмжийн ур маяг, үг хэлний онцлогоос харж болохоор байдаг. «Ойлгомжтой бичигчийг уншигч хүлээж байдаг бол, бүрхэг бичигчийг тайлбарлагч хүлээдэг»⁵ гэж Герихийн хэлсэн

мэргэн үг бий. Үнэхээр уншмагц утга нь сэтгэлд зурсхийн бууж ирэхүйц ойлгомжтой, оновчтой бичдэг Ц.Дашдондовын үр чадварын олон нууцын нэг нь яах аргагүй үг хэлний өвөрмөц байдал мөн. Нийтлэл бүтээлийг яруу тансаг, оновчтой ойлгомжтой үг хэлээр бичихийн тулд төрөлх хэлний гүн бат мэдлэг эзэмшиж, утга зохиолын хэлний найруулгын хэм хэмжээг мөрдөж сурсан байх учиртай. Ц.Дашдондовт энэ талын мэдлэг туршлага дутахын зовлонгүй, төрөлх болон гадаад хэлний мэдлэг тэгширсэн нэгэн билээ. Тэрбээр юуны өмнө Монголын орчин цагийн нэртэй толь зүйчдийн нэг юм. «Монгол-орос өврийн толь»,

«Монгол-орос-англи өвөрмөц хэллэг», «Монгол-англи шинэ тайлбар толь», «Орос-англи хэлний хураангуй үгийн толь» гэх мэт арав гаруй бэсрэг, дунд даяг зохиосон байна. Энэ тухайд «Орост суралгүй, Америкт аж төрөлгүй, Афинд очилгүй хэл сурсан шиг сурч, хэлшинжлэл дагнасан шинжлэх ухааны байгууллагын хүндэт доктор, олон хэлний харьцуулсан толийн зохиогч болж эрдэм ухаанд шамдахад онцгой халамж, тусгай нөхцөл гол бишийг харуулж ялж дийлэв»⁶ гэж мэргэжил нэгтний нь хэлсэн үг оносон үнэлгээ болсон юм. Тэрбээр өөрөө ч харь хэл сурахыг хялбарт бодож «хүйтэн цай залгилж, зайдан моринд мордох» лугаа «нимгэнд санаж, хөнгөнд тооцож»⁷ болохгүйг анхааруулаад авсан байдаг. Мөн өөрийн бүтээлийг шинээр эзэмших хэлнийхээ «шимийг хүртэж, шидийг нь

үзэх» гэсэн «чин хүсэл, чиглэсэн зорилготой, оргилуун эрмэлзэл, даргилуун тэмүүлэлтэй», эрдэмд шамдах «эрүүл бодол, саруул ухаантай» тэнгэрлэг хүмүүст тухайлан зориулснаа тов тодорхой илэрхийлсэн байна. Тийнхүү эх хэлнийхээ үгийн хүдрийг тунгааж, харь хэлтэй харьцуулан дүйлгэж дадсан бичгийн хүний туурвилаас үг, утгын гажиг олно гэдэг өвсөн

дундаас зүү эрэхтэй адил юм. Харин ч бүтээл туурвилыг нь ул суурьтай судалж, уншууртай, ухааруулах увдистай нийтлэлүүдийнх нь бүтэц зохиомж, үг хэлний яруу сайхнаас шимтэн суралцах нь залуу сэтгүүлч, нийтлэлчдийн үүрэг

«

Нийтлэл бүтээлийг яруу тансаг, оновчтой, ойлгомжтой үг хэлээр бичихийн тулд төрөлх хэлний гүн бат мэдлэг эзэмшиж, утга зохиолын хэлний найруулгын хэм хэмжээг сурсан байх учиртай. Ц.Дашдондовт энэ талын мэдлэг туршлага дутахын зовлонгүй, төрөлх болон гадаад хэлний мэдлэг тэгширсэн нэгэн билээ.

»

болох ёстой юм.

Ийм зорилгын үүднээс анхааралтай тунгааж үзвэл Ц.Дашдондовын нийтлэлийн хэл найруулгад дараах хэдэн онцлог байгааг харж болно. Юуны түрүүнд тэрбээр монгол хэлний сонгодог найруулгын уламжлалт зарчмыг гайхалтай мөрддөг уран бүтээлч юм. Монгол бичгийн найруулгад тэгш хэмийн зарчим хийгээд түүнээс шууд улбаатай сондгойруулахгүй байх, яруу сонсголонтой байх гэсэн хоорондоо нягт уялдаатай, нэг нь нөгөөгөө нөхөж, нөхцөлдүүлж байдаг язгуур гурван зарчим байдаг. Ц.Дашдондовын нийтлэлд энэ зарчмаар бичсэн үг хэллэг, өгүүлбэр, мөчлөг, хэсэг захаас аваад зуршмал байгааг түвэггүй харж болно. Аль тэртээх наяд онд Зөвлөлт улсад өрнөж байсан өөрчлөн байгуулалтын тухай бичсэн нэгэн нийтлэлд «Амьд

ажлыг бичиг цаасаар орлуулахгүй, аливаа хурц асуудлаас тойрч халгаад байхгүй, амжилт ололтыг юм юмны хаалт болгохгүй, албан тушаал мэтээр хэзээ ч түрээ барихгүй» гэхчилэн бичиж байжээ. Энэ өгүүлэмжид хоёр олзуурхуштай чанар байна. Үүний нэг нь өгүүлбэрийн зэрэгцсэн гишүүдийг толгой холбох аргаар байрлуулж сонсголт чанарыг сайжруулсан, нөгөө нь гишүүн өгүүлбэрийн үгийн тоог адилхан буюу ойролцоогоор 5-6 үгээр найруулж хэмнэл оруулсан явдал мөн. Ингэснээр өгүүлбэр тэгш хэмтэй болж, сонсголт чанар нь сайжирсан байна. Уг өгүүлбэртэй залгаад «голч шударга, ажил хэрэгч, ил тод, эмх цэгцтэй» ажиллах журмыг мөрдөх тухай өгүүлсэн хэсэгт мөн л өгүүлбэрийн гишүүдийг адилхан хоёр үгээр хоршин найруулснаар сондгойруулахгүй байх зарчим хангагдсан байна.

Түүнчлэн «Ухрах уу, урагшлах уу?» («Цаг цагийн аяс» ном. 1996. 231-235 дахь тал) өгүүлэлд «Хүнс бараа ховор, юмны үнэ өндөр, цалин хөлс бага, амьжиргааны түвшин доогуур, амьдрал баталгаагүй» гэх мэтээр бас л уламжлалт зарчмыг баримталж бичсэн өгүүлэмж олон байна. Тухайлбал Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөрт зориулж «Өглөөний сонин»-ы 2012 оны №087 (1424) дугаарт нийтлүүлсэн өгүүлэлд «Хатан зориг гаргаж, хатуу үгээр гүвшиж, хайр найргүй тэмцэж», «Шүүмжилж байгаа нь энэ гээд доромжилно, илчилж байгаа нь энэ гээд гүтгэнэ, эрэн сурвалжилж байна гээд ул шагайна», «Бат тууштай, баримтлах зарчимтай» гэх мэтээр бичсэн бол, нэрт эрдэмтэн Чой. Лувсанжавын тухай дурсамж тэмдэглэлд түүний үйл хэргийг дүгнэж «Алдсан нь бага, оносон нь их, алгуурласан нь өчүүхэн, амжуулсан нь үлэмж» гэсэн

нь чухам л нэг донж нь таарсан өгүүлэмж болжээ.

Монголчууд эрт үеэс ном зохиолыг гүйлгэх, гинших, үелэх гэсэн гурван аргаар уншдаг байж. Энэ гурван арга тус тусын зорилготой байсан. Бичсэн зүйл аль хэр цэгцтэй, яруу сайхан болж байгааг шалгаж, ариутган шүүх хүн гиншиж уншдаг байв. Ингэж уншихад өнгө аяс таараагүй, үг, мөр сондгойрсон газарт нэгэн хэмийн аялгуу дуудлага алдагдаж, морь бүдрэх мэт болдог байна. Сайн болсон бичвэрийг аялгуулан уншихад хээр талд задгай суман хатираатай мориор давхих шиг саадгүй сайхан байдаг аж. Ц.Дашдондовын бичсэн нийтлэл энэ шаардлагад тохирохуйц байдаг нь нэгэн үнэт чанар юм.

Хэрэв түүний туурвилын хэл найруулгыг Дандийн «Зохист аялгууны толь»-д дурдсан барилдлага, маш тунгалаг, тэгш чанарт, яруу, маш яруу, тодорхой утгат, аугаа их чанарт, жавхлант, үзэсгэлэнт, самади гэх зэрэг найруулгын арван эрдмийн шалгуураар нарийвчлан судалж үздэгсэн бол олонход нь тэнцэх байх. Ийм үгийг «Ирээдүй өөд даллаж, эрч хүч нэмж», «Ирлэж хурцалсан, илч бадруулсан», «Бодлын богцоо нээж, оюуны ордоо онгичиж», «Ололтоо бүртгэхдээ орхисноо үгүйлэх, амжилтаа ярихдаа алдсанаа санах», «Алдаг оног цугладаг, асуудлыг хам хум шийддэг», «Тод мөртэй, хос морьтой», «Эрхээ эдэлж, үүргээ биелүүлэх», «Үс цайж, чөмөг дундрах», «Хүн болгон руу дайрч, юм болгон руу нулимах», «Хэрээрээ хичээж, тараараа зүтгэх», «Дээд комиссын гойд шинж» гэх мэт цаанаа л нэг хий нь гарч цэнэгшсэн, хэнийхтэй ч адилгүй ондоошсон үг хэллэг түгээмэл тааралдаж байгаад түшиглэн хэлж болох юм.

Ц.Дашдондовын нийтлэлд авиагаар найруулах, толгой сүүл холбох зэргээр бичсэн зүйлээ эгшиг сонсголонтой болгох аргыг өргөн хэрэглэсэн байна. Жишээ нь «Америкт явсан аяны богцоо задлахуй» ("Монголын мэдээ". 1999. №180) гарчигтай тэмдэглэлд «Дон дон гэсэн жол жол асуулт», «хөх дэлэн, хөнжил дэвсгэр» гэх мэтээр бичсэн байна. Тэрбээр бас үгийн өнгө аялга, авиа зохицол, дуу чимээг тааруулах, үг холбох, давтах зэргээр утга санаа, дүр дүрслэлийг тодруулах аргыг төгс эзэмшсэн уран бүтээлч юм. Жишээ нь «Хэлээгүй орхисон, өгүүлээгүй үлдсэн», «Зовиурыг арилгаж, зовлонгоос ангижруулсан», «Хуримталсан туршлага арвинтай, хур мэдлэг сайтай» гэх мэт ижил буюу ойролцоо утгатай үг хэллэгийг хорших, давтах аргаар утга санааг гүнзгийрүүлж, уншиж ойлгоход дөхөмтэй болгосон өгүүлэмж захаас аван тааралдаж байна.

Ц.Дашдондовын нийтлэлд оновчтой зүйрлэл, хурц тод дүрслэл арвин байгааг түвэггүй мэдэж болно. Жишээ нь «Хүний нэр төр бол хэн ч хамаагүй довтолдог хөлбөмбөгийн хаалга биш, харин халдашгүй хэрэм, хамгаас нандин цайз», «Чөлөөт хэвлэл бол галзуу нохой биш, харин хоточ нохой байх учиртай», «Сэтгүлчид гэмээнэ гангаар бүтсэн хүмүүс биш тул тэдэнд нийгэм хайр хүндэтгэлтэй хандаж байвал зохино» гэх мэтээр бараг өгүүлбэр болгондоо зүйрлэл, адилтгал хэрэглэдэг нь түүний дархан мэх болжээ.

Ц.Дашдондовын нийтлэлд зүйр, цэцэн үг мэт оновчтой үг хэллэгийг бодож олоод хэрэгтэй газарт нь шигтгэж өгдөг, өөрөөр хэлбэл үг бүхэн үүрэгтэй, өөрийн гэсэн байртай байдаг нэг онцлог бий. Үүнийг нь «Хоцорсон дээрээ хоцрох, доройтсон дээрээ доройтох», «Өрөвдүүлж явснаас

атаархуулж явсан нь дээр», «Сөрж давах болохоос, сөгдөж бууж өгөхгүй», «Оюуны ордоо онгичиж, олсон олзоо хуваалцах», «Үзгэн шилбүүр барьж, үгийн сүрэг гилж», «Амжилтаа дурдаа алдаагаа нуух, ололтоо тоочихдоо орхисноо эс үгүйлэх», «Шугам хийхэд шулуун мод хэрэгтэй ч, эмээлийн бүүрэг хийхэд ээтгэр мод тохирно», «Муу байхад амар, сайн явахад хэцүү», «Хэлгүй сэтгүүлч ишгүй сүхтэй ижил», «Хааж чадахгүй хаалгыг нээхийн хэрэггүй», «Тэр гэх тэмдэггүй, энэ гэх эзэнгүй» гэх мэт оносон үг хэллэгүүд гэрчилнэ. Тэрбээр бас ардын зүйр, цэцэн үгийг бичиж байгаа зүйлийнхээ санааг чангаруулах зорилгоор хэрэгтэй газарт нь тун ч оновчтой шигтгэж өгсөн байдаг. Жишээ нь «Хүний муу хүн дайрдаг, хүрзний муу чулуу дайрдаг», «Хүн ёс дагана, нохой яс дагана», «Сайн нь муутайгаа нийлж гэр дүүрдэг, сархинаг гүзээтэйгээ нийлж тогоо дүүрдэг» гэх мэт үгс хэрэгтэй газраа олж, хэлэх гэсэн санаатайгаа ижилсэхээр чухам л нэг "чинжүүтэй" өгүүлэмж болж байгааг түүний нийтлэлээс харж болно.

Өөр бас нэг өвөрмөц юм гэвэл, яг л шинжлэх ухааны тодорхойлолт шиг юмны мөн чанарыг гайхалтай илэрхийлсэн сургаал, дүгнэлтийн шинжтэй үг хэллэгүүд Ц.Дашдондовын нийтлэлийг улам хурцалж, үлэмж зангарагтай болгодог явдал мөн. Тухайлбал «Могой, зараа хоёр нэг дор байдаггүй», «Чөлөөт хэвлэл бол хүн чанарын шалгуур», «Өөг нь өөхөөр хучих гээд хэрэггүй», «Засгийн газар, хэвлэл хоёрын хооронд янагийн холбоо байж таарахгүй», «Шинэ цаг үед хуучин хэмжүүр тохирохгүй», «Хэвлэлийн эрх чөлөө бол төр засгаас түгээдэг хишиг биш», «Хэчнээн өлслөө ч гэсэн сэтгүүлч сэтгүүлчээ

идэж болохгүй» гэх мэтийг дурдаж болно.

Ц.Дашдондов сүүлийн хэдэн жилд «Бийрээр бичсэнийг балтаар цавчсан ч үл балармой» гэдэг нэртэй гурван дэвтэр ном бүтээсэн нь учир утгатай, ухааны цараатай аж төрж, нэгэн насны амьдралаа утгын таяг тулж, үгийн сүрэг гилж өнгөрүүлснийх нь нэг ёсны тайлан болсон гэлтэй. Энэ номыг уншиж суухад «алт удах тусмаа өнгө ордог» гэсэн үг өөрийн эрхгүй санаанд орж ирсэн юм. Үүгээрээ би нас ахиж, туршлага зузаарах тутам сэтгүүлчийн маань нийтлэл улам жин дарж, үг хэл нь хурц оновчтой болжээ гэж хэлэх гэсэн юм. Энэ номд орсон нийтлэл, дурсамж, тэмдэглэлүүдэд дээр дурдсан тэгш хэмтэй байх, сондгойруулахгүй байх, яруу сонсголонтой байх зарчмуудыг ягштал баримталсан өгүүлэмж бараг өгүүлбэр болгонд тааралдаж байна. Үүнд «Учигны үзүүр, уяаны гогцоо», «Халуун тус, дэлгэр дэм», «Ухааны цараа, утгын шим», «Ирээдүй өөд даллаж, эрч хүч нэмж», «Ирлэж хурцалсан, илч бадруулсан», «Дал гарсан, дол цохисон», «Хуучны хулуу, хожуулын цог»⁸ гэх мэтээр өгүүлсэн байх жишээтэй байна.

“Ү г бүхэн нь яруу найраг” гэдэг шиг Ц.Дашдондовын нийтлэлийн гарчиг нь хүртэл онч мэргэн үг оруулж, адилтгал зүйрлэл ашиглаж, аялгуу хэмнэл тааруулсан байдаг онцлогтой байна. Жишээ нь «Мэргэн Күнзийн онолын цараа, Мэнэрэлийн Чимэдцээгийн орчуулгын чансаа», «Бүгдийн хүндлэл хүлээсэн Бүлтэн хэмээх ачтан», «Орчуулахын омтгой, хэлэхийн хэлтгий, ярихын яйтгий», «Цалгилж буй далай, цахилж буй гөрөөс лугаа цоглог нэгэн байлаа» гэх мэт содон гарчгууд түүний нийтлэлд хэм хэмжээ болж тогтжээ.

Ц.Дашдондов «Мэргэн Күнзийн онолын цараа, Мэнэрэлийн Чимэдцээгийн орчуулгын чансаа» өгүүлэлдээ Күнзийг «Энгийн гэдгээс ихэд хальсан, дээдэс бүхнээс дэндүү давсан, суу билэгт, сод ухаант» нэгэн байсан тухай өгүүлсэн бол, түүний сургаалд «Өршөөл энэрэл, өрөвч сэтгэл, хэв ёс, хэм сахилт, тэгш дундаж»-ийг бататган дээдэлсэн байдаг тухай хэм тэгш, яруу сайхан өгүүлсэн байна. Тэрбээр бас Күнзийн сургаалыг орчуулсан М.Чимэдцээг «Хур мэдлэг, хуримталсан туршлагатай, бядтай сэтгэж, бялттай бичдэг» хэмээн үнэлсэн юм.

«Бүгдийн хүндлэл хүлээсэн Бүлтэн хэмээх ачтан» тэмдэглэлд эх баригч эмч гэдэг «Амь дүйсэн, авхаалж шаардсан, эрсдлээр дүүрэн, эгэл бус» мэргэжил болохыг онцлон тэмдэглэжээ. Уг тэмдэглэлд бас Бүлтэн эмчийн эрдэм мэдлэг, хичээл зүтгэлийг «Эхэд тулгарах эрсдэл, урагт учрах аюул, төрөхөд тохиолдох хүндрэл, нялхсыг нэрвэх эндэл»-ээс сэрэмжилж, «Зүйрлэшгүй самбаа гаргаж, сааршгүй санаа тавьж, ирэх эрсдэл, учрах уршиг»-ийг зайлуулдаг гэхчлэн бичсэн нь цөөн үгэнд их санаа багтаасан цэгцтэй өгүүлэмж мөнөөс мөн байна. Түүнчлэн Бүлтэнгийн өнөөгийн ажил үйлсийг анх эмч болж байсан үетэй нь харьцулахад «Өөдөө гарч, өндөр авч, өнгөлөг яваа» гээд, үүнд хангай шиг түшигтэй ханийн нь «халуун нөөлөг, дэлгэр дэм, тулгар тус» тун чиг чухал байсныг мөнөөх л тэгш хэмийн зарчмаар сэтгэлд шингэцтэй, ухаанд үлдэцтэй өгүүлээд авчээ. Энэ тэмдэглэлд «Ажил үйлс нь амаргүй, ач тус нь аугаа», «Их өндөр соёл, эрхэмлэн нандигнах зан үйл» гэх мэт сондгойруулахгүй байх зарчмаар бичигдсэн үг хэллэг олон байна. Тэмдэглэлийнхээ төгсгөлд Бүлтэн болон түүний гэр бүлийнхэнд хандаж «Эмч

Бүлтэнд өөрт нь, эр нөхөрт нь жичид нь, энэрэлт үрс цөмд нь, аз жаргал, амжилт бүтээл, ашдын сайхан»-ыг ерөөе гэж мөнөөх л ая дангаа алдалгүй өгүүлжээ. Тэмдэглэлийн хэл найруулгыг бүхэлд нь аваад үзвэл гүн утга, яруу хэллэгийн цогцлол болсон байна. Одоогоос олон арван жилийн өмнө Оросын их зохиолч А.М.Горький сэтгүүлчдэд хандаж «Та бүхэн олон сая хүнд зориулан бичиж байна гэдгээ мартаж болохгүй. Иймээс нягт нямбай ажиллаж, үгийг оновчтой зөв хэрэглэн яруу хурц бичиж, өөрийн туршлага, сэтгэгдлийг олон сая уншигчид туйлын нарийн тодорхой нэвтрүүлэх арга ухаан бүрийг эзэмших хэрэгтэй» хэмээн захиж байжээ. Тэрхүү шаардлагыг бүрэн дүүрэн хангаж, нягт нямбай ажиллахын үлгэр жишээг үзүүлж чаддаг сэтгүүлчийг аваад ир гэвэл Ц.Дашдондовыг л хамгийн түрүүнд хөтөлж ирэх хэрэгтэй болно гэдэгт энэхүү төсөрхөн өгүүллийг тэрлэгч эргэлзэхгүй байна.

Ц.Дашдондовын нийтлэлийн хэлийг зөвхөн үг зүй, өгүүлбэр зүйн хүрээнд, эсвэл дан ганц найруулгын түвшинд салган авч үзэх нь хангалтгүй юм. Түүний үг хэлний ончтой, цэцэн цэлмэг байдал, өгүүлэмжийн логик дараалал нийтлэл бүтээлийнх нь агуулгад хэрхэн нөлөөлж байгаа нь анхаарал татдаг. Аливаа бичмэл зүйлийг бид "эх бичвэр" гэсэн нэр томъёогоор тэмдэглэж заншсан. Эх бичвэрийг хэл шинжлэлийн онолд олон янзаар тодорхойлсон байдаг. Харин сэтгүүл зүйн үүднээс авч үзвэл тэр нь «Зохиогч, хүлээн авагч хоёрын хооронд харилцааны янз бүрийн үүрэг гүйцэтгэх зорилгоор тардаг мэдээлэл», түүнчлэн «Агуулга, хэлбэрийн нэгдлийн үр дүнд нөхцөлдөн барилдсан нэг утгат үзэл санаа»⁹ юм. Ийнхүү нэг утгатай байхын чухал

нөхцөл нь эх бичвэрийн харьцангуй бие даасан нэгж болох бүлэг өгүүлбэрүүдийн уялдаа холбоо мөн. Өөрөөр хэлбэл бичвэрийг бүрдүүлж байгаа мөчлөг, хэсгүүдийн утга санаа нэгээс нөгөөд шилжин үргэлжлэхдээ агуулгынхаа харилцааг хадгалж байх шинж буюу эх бичвэрийн тасалдалгүй тууштай чанар юм. Ц.Дашдондов нийтлэл бүтээлдээ ийм чанарыг шингээж чаддаг сэтгүүлч мөн. Түүний нийтлэлийн агуулга өгүүлбэрээс өгүүлбэрт, мөчлөгөөс мөчлөгт улам бүр цэгцэрч чангараар нэгэн цогц үзэл санаа болж биеждэг онцлогтой байна. Хоёрдмол санаа, ойлгомжгүй өгүүлэмж, эргэж буцсан, эздэрч будилсан зүйл ер байдаггүй.

Ер нь эх бичвэр (textus) гэдэг нэр томъёо анх "сүлжмэл", "хэлний сүлжмэл" гэсэн үгнээс үүсэлтэй гэдэг. Тэгэхээр бичсэн зүйл үг хэлний түвшинд ч, агуулгын түвшинд ч нэхсэн, сүлжсэн бөс даавуу мэт жигд бөгөөд нягт барилдсан байх ёстой. Тэгэж чадсан эсэхийг бичвэр бүхэл бүтэн, харилцан холбоотой, бат бөх байх гэсэн гурван шалгуураар хэмждэг. Ц.Дашдондовын нийтлэл энэ шалгуурыг "ногоон гэрэл"-ээр давж чаддаг нь түүний хэлний цэгцтэй байдал, сэтгэлгээний тууштай чанарын үр дүн ажээ. Энэ нь түүний нийтлэл халдашгүй дархан буюу хэн ч, хаана нь ч үзэгний үзүүр хүргэхээс зүрхшмээр байдгаар тайлбарлагдана. Учир нь эх бичвэрийн нэгдэл, холбоо, бат бөх байдал нь огт эсрэгээр буюу түүний эмзэг байдлаар илрэн гардаг юм. Ц.Дашдондов нэгэнтээ «Үзэг барьж, үг хэлхдэг хүн бүр чухам л нэг элгэн тараг шиг нийцтэй, наалдацтай өгүүлж сурах хэрэгтэй юм даа» хэмээн хэлж билээ. Энэ нь энгийн нэг монгол үнэр ханхалсан үг боловч, цаагуураа утга зохиол, хэл шинжлэ-

лийн онолын нарийн асуудлыг монгол хүний сэтгэхүйд тохируулан туйлын оновчтой тодорхойлсон хэрэг юм.

Ц. Дашдондовын нийтлэлийг ажиглаж үзэхэд уран бүтээлчийн сэтгэлгээний тууштай байдал нь хэлний цэгцтэй өгүүлэмжийг бүрдүүлж, улмаар агуулгын цул нэгдлийг буй болгодог үр нөлөөний гинжин холбоог харж болохоор байна. Бас сэтгүүлч хүн бурууд хатуу, зөвд зөөлөн байх учиртайг түүний бүтээл хэлж өгдөг. Түүний нийтлэл дэх шүүмжлэл, эсэргүүцэл, эргэцүүлэл нь зүрхэнд хүрч, тархинд харвах үгэн сум байдаг бол, зөв явдалтай, зөөлөн сэтгэлтэй хэнээс ч дэм болж, дээш нь татсан сүү шиг үгээ харамладаггүй аж. Үүнийг буруутныг бут ниргэж, буянтныг зад магтсан олон нийтлэл гэрчилнэ. Эцэст нь дүгнэж хэлэхэд Ц.Дашдондов цэгцтэй үгээр бүтсэн цогцтой санаа бүхий шилдэг нийтлэлүүдээрээ Монголын сэтгүүл зүйн туурвилд давтагдашгүй ул мөр үлдээж, үзгэн моринд дөрөөлж, үгэн хөрөг бүтээж явсныхаа өндрөөс өндөр хөшөөг босгож амжсан манай үеийн шилэгдмэл сэтгүүлч мөн.

Ишлэл

¹ Норовсүрэн Л. 2007. Монголын нийтлэл. Гутгаар боть. УБ., 21 дэх тал.

² Дашдондов Ц. 2010. Бийрээр бичсэн нийг балтаар цавчсан ч үл балармой. УБ., 88 дахь тал.

³ Либкнехт В. 1976. Из воспоминаний о Марксе // К.Маркс, Ф.Энгельс об искусстве. Т. 2., М., с. 556.

⁴ Чулуунбаатар До. 2004. Ялж дийлэхийн ухаан. УБ., 5 дахь тал.

⁵ Норовсүрэн Л. 2008. Хянан найруулах ухаан. УБ., 14 дэх тал.

⁶ Чулуунбаатар До. 2004. Ялж дийлэхийн ухаан. УБ., 104 дэх тал.

⁷ Дашдондов Ц. 2012. Харь хэлний хатуу самар цөмөгчдөд. УБ., 7 дахь тал.

⁸ Дашдондов Ц. 2010. Бийрээр бичсэн нийг балтаар цавчсан ч үл балармой. III дэвтэр. УБ., 14-49 дэх талаас түүвэрлэв.

⁹ Норовсүрэн Л. 2008. Хянан найруулах ухаан. УБ., 126 дахь тал.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Баасансүрэн Т. 2009. Монголын чөлөөт хэвлэлийн хөгжилд үндэсний сэтгүүлчдийн уран чадвар нөлөөлсөн нь. УБ.

2. Дашдондов Ц. 2010. Бийрээр бичсэн нийг балтаар цавчсан ч үл балармой. III дэвтэр. УБ.

3. Дашдондов Ц. 2010. Бийрээр бичсэн нийг балтаар цавчсан ч үл балармой. III дэвтэр. УБ.

4. Дашдондов Ц. 2012. Харь хэлний хатуу самар цөмөгчдөд. УБ.

5. Норовсүрэн Л. 2007. Монголын нийтлэл. Гутгаар боть. УБ.

6. Норовсүрэн Л. 2008. Хянан найруулах ухаан. УБ.

7. Норовсүрэн Л. 2011. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. Гутгаар дэвтэр. УБ.

8. Чулуунбаатар До. 2004. Ялж дийлэхийн ухаан. УБ.

9. Либкнехт В. 1976. Из воспоминаний о Марксе., В. кн. К.Маркс, Ф.Энгельс об искусстве. Т-2. М.

Abstract

In this story, Mongolian famous journalist Dashdondov Ts's literary language's characteristics and skills in his publications were studied. Within his publications, adherence of using methods like symmetry, pairing and narrating symphoniously in Mongolia's classic literary languages were unveiled and valued in analysis of his certain publications.